

МАНЖИЙН ЭРХШЭЭЛИЙН ҮЕИЙН МОНГОЛЫН ТҮҮХИЙГ СУДЛАХ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ж.Болдбаатар

Монгол Улсын Их Сургууль. Түүхийн судалгааны хүрээлэн

Jigjid_boldbaatar@yahoo.com

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийг судлахдаа, нарийн үечилж, үе бүрийн шалгуурыг нуттай баримттай тогтоох нь зүйтэй гэж үзэж, энэ үеийн түүхийг XVII-XIX зууны эхэн үе (түшмэг хараат), XIX зууны эхэн үеэс эцэс (хагас колоничлол), XIX зууны эцсээс XX зууны эх (бүрэн колоничлох бодлого) хэмээн үечилжээ. Мөн энэ үеийн түүхэн нэр томъёог оновчтой болгох тодорхой санал дэвшүүлсэн байна.

Түлхүүр үг: үечлэл, ноёрхол, бэрхшээл, талхигдал, боолчлол, домнион, түшмэг хараат, хагас колоничлол, колоничлол, шинэ засгийн бодлого, бослого хөдөлгөөн, үндэсний хувьсгал

XVII-XX зууны эхэн үе бол Монголын түүхийн хамгийн ээдрээтэй, нэгдмэл үндэстний хувьд бууран доройтсон үе юм. Энэ үеийн түүхийг судлах талаар дотоод, гадаадын олон эрдэмтэд хүчээ сорьжээ¹. Эдгээр судлаачдаас “Халхын түүх”, “Монголын феодализмын үндсэн замнал” зэрэг бүтээл туурвисан академич Ш.Нацагдорж хамгийн дорвилог нь юм. Гэвч монголын эрдэмтэд түүхэн цаг үеийн эрхээр түүхийг үзэх марксист онол арга зүйд тулгуурлан, зохиол бүтээлээ туурвиж байв. Ийм учраас бидний эрдэмтэн багш нарын туурвил тухайн цаг үеийнхээ алдаа, гажуудлыг зохих хэмжээгээр агуулж байв. “Бойтог өмсөөд, Богд уулаа өшиглөв” гэгч болж байгаа юм биш. Ер нь түүхийн үүднээс сэтгэнэ гэдэг тухайн эрин цагийнхаа оршин тогтнох эрхийг, түүндээ тохирсон төгс боловсронгуй цаг байсныг хүлээн зөвшөөрнө гэсэн үг ээ.

Эдүгээ бид Монголын түүхийг бүхэлд нь дан ганц марксист онол-арга зүйн үүднээс судалж, туурвиж байснаа эргэн харж, монголчуудын түүх бичлэгийн уламжлал, өрнө, дорнын олон онол суртлын уулзвар, бэлчээр зангилаан дээр шүтэлцүүлэн барилдуулж, дахин эргэцүүлэх шаардлага тулгарч байна. Үүнд Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүх шууд хамаарна. Энэ үеийн Монголын түүхийг дахин эргэцүүлэн судлахад дараах хэдэн гол зүйлд юуны түрүүнд оюун бодлоо төвлөрүүлэх нь зүйтэй болов уу. Үүнд:

1. Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийн эх сурвалжуудыг эх бичиг судлалын үүднээс төдийгүй, түүх бичлэг, түүхэн утга зүйн үүднээс улам гүнзгийрүүлж, нягтлан судлах шаардлагатай байна. Энэ талаар зарим ахиц дэвшил гарч эхэлж байгаа нь сайшаалтай. Тухайлбал, профессор Ш.Чоймаа, А.Цанжид нарын удирдлагаар “Монголын түүхэн сурвалжийн дээжис” хэмээх

¹ Владимирцов Б.Я. Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. Лг, 1934. Горохова Г.С. Очерки по истории Монголии в период маньчжурского господства (конец XVIII века начало XX вв) М.1980. Златкин И.Я. Очерки новой и новейшей истории Монголии М. 1957, Д.Гонгор. Халх товчоон I. Халх монголчуудын өвөг дээдэс ба Халхын хаант улс (VIII-XVII). УБ.1970. II Халх монголчуудын нийгэм-эдийн засгийн байгуулал. (XI-XVII) УБ.1978. Ц.Насанбалжир. Манж Чин улсад Ар монголоос нийлүүлж байсан алба (1691-1911) УБ. 1964. Манжийн үеийн албат сум ард. УБ.1958. Монголын аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэтгэл. УБ. 1978. Ш.Нацагдорж. Халхын түүх. (1691-1911) УБ. 1963. Сум, хамжлага, шавь ард. УБ.1971. Монголын феодализмын үндсэн замнал. УБ. 1978. М.Санждорж. Халхад Хятадын худалдаа, мөнгө хүүлэл нэвтэрч хөгжсөн нь. (XVIII) УБ.2001. Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт. (1691-1911). УБ.1961. Цан дай мэнгү ши (Лу мин хуй. Чин улсын үеийн Монголын түүх) 1990. Udo B.Barkmann. Geschichte der Mongolei oder Die „Mongolische Frage“ Die Mongolien auf ihrem wed zum eigenen Nationaltaat. 1909. BOUVIER VERLAG-BONN. гэх зэрэг.

цуврал 30 ботийг монгол бичгээс кирилл бичигт буулган эмхтгэсэн явдал юм. Гэхдээ зүгээр л нэг эмхтгэсэн биш:

Нэгд, өмнө энд тэнд гарч байсан хэвлэлүүдийг монгол эрдэмтний ухаанаар шүүн, уг эхээсээ зөрсөн алдаа мэдгийг залруулсан,

Хоёрт, түүхэн үйл явдал, хүний нэр, он цаг гэх мэт олон зүйлийг янз бүрийн сурвалжид өөр өөрөөр бичсэнийг харшуулан үзэж тайлбар хийсэн,

Гуравт, өнөө үед ойлгохоо больсон монгол, төвд, манж, хятад хэлний үг хэллэгийг тайлбарласан зэрэг болой². Эдгээр цуврал ботид орсон сурвалжуудын тал илүү нь Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийн асуудлыг хөндсөн байна. Түүнчлэн хятад, манж, түвд, орос хэлээр буй сурвалжууд, архивын сан хөмрөгийг судалгааны эргэлтэд оруулах талаар зарим ахиц гарч байна³. Эл хэрэгт манай өвөрлөгч судлаачид томоохон хувь нэмэр оруулж байна. Ялангуяа Үндэсний архивын манж хэлээр буй фондыг өргөн ашиглах талаар дорвитой алхам хийх нь чухал юм.

2. Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийг үнэн зөвөөр судлахын тулд энэ үеийн нэр томъёог зөв тогтоон хэрэглэх, историзмын түүхэн утга учрыг зөв илэрхийлэх шаардлагатай юм. Өмнөх үеийн түүхэн утга зохиолуудыг шүүрдэн үзвэл, Манжийн эрхшээлийн үеийг “Манжийн ноёрхолын үе”, “Манжийн талхигдлын үе”, “Манжийн дарлалын үе”, Манжийн боолчлолын үе”, “Манжийн колоничлолын үе”, Манжийн эрхшээлийн үе” гэх мэт олон янзаар томъёолохын хамт Монголын статус-квог колони, вассал, доминион гэх мэтээр тодорхойлж иржээ. Энэ маягаар асуудлыг томъёолохуйд хайр гамгүй хандан, өөр өөрийн үзэл бодлоор олон янзын нэр өгч ирснийг цэгцэлмээр байна. Энэ үеийн нэр томъёонд ангич байр суурь, агуулга хүчтэй илэрч буйг анхаарах ёстой. Бидний хувьд “Манжийн эрхшээлийн үеийн Монгол орон” гэсэн томъёолол илүү үндэслэгээтэй болов уу.

3. Улиран өнгөрсөн тогтолцоонд Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийг националист түүх бичлэг буюу үндэсний үзлийн үүднээс бичиж байсныг дахин эргэцүүлж, тухайн түүхэн цаг үеийн Монголын статус-квог зөв чиг баримжаатай тодорхойлох явдал чухал болж байна.

1990-ээд оноос өмнөх түүх бичлэгт дээр дурьдсанчлан нэр томъёог хайр найргүй хэрэглэж байсан боловч БНМАУ-ын түүхийн гурван боть зохиолын III ботид колончилал хэмээх нэр томъёог хэрэглэхээс аль болох зайлсхийсэн байна. Харин нэлээд хожуу үед эл үйл явдлыг зарим түүхчид “Халхын хар, шар феодалууд эх орноосоо урваж, манжийн түрэмгийлэгчдэд төрөлх нутаг, ард түмнээ худалдсаар...Халх Монгол улс төрийнхөө тусгаар тогтнолыг алдаад ... манж гүрний зах хязгаарын халхавч болсон колоний орон” болсон “Монгол дахь Манжийн колоничлолын дэглэм ...империализмын үеийнхээс эрс өөр ... XIX зууны эцсээс Монгол орон феодализмын үеийн уламжлалт манжийн колоничлох бодлогыг амсч байхын зэрэгцээ, бас империалист колоничлолд хэлмэгдэх болов”⁴ гэх зэргээр үзсэн байна.

² Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. I-XXX боть. УБ.2006

³ Дундат улсын түүхийн нэгдүгээр архив. Арван долдугаар зууны өмнө хагаст холбогдох монгол үсгийн бичиг дэвтэр. (Эмхтгэсэн Ли баом) 1997, Материалы по истории русско-монгольских отношений 1636-1654. Сборник документов. Составители М.И.Гольман, Г.И.Слесарчук Москва, 1974. Материалы по истории русско-монгольских отношений 1654-1685. Сборник документов. Составитель Г.И.Слесарчук Москва, 1996. Материалы по истории русско-монгольских отношений 1685-1691. Сборник документов. Составитель Г.И.Слесарчук Москва, 2000. XVII-XX зууны эхэн үеийн Монголын түүхийг судалсан бүтээлийн ном зүй. Эмхтгэсэн Э.Жигмэддорж. УБ, 2007

⁴ Ш.Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа. (1850-1919). Тэргүүн дэвтэр. УБ, 1973

1996 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Их Монгол Улс байгуулагдсаны 790 жил, Ардын хувьсгалын 75 жилийн ойн баярын хурал дээр тавьсан илтгэл болон дараа нь “Тэнгэрийн цаг” хэмээх дуртгал номондоо: “Монгол улс тусгаар тогтнолоо алдан устаж, Манжид эзлэгдээгүй”, Монгол 1691-1911 он хүртэл 220 орчим жил” харьцангуй бие даасан байдлаа хадгалсан, Манж чин улсын нэг ёсны доминион байсан⁵ гэж хэлсэн юм. Энэ бол Ерөнхийлөгчийн хийсвэр бясалгал биш, нэг хэсэг түүхчдийн бодол санааны илрэлийн тусац бүлгээ. Англи, Герман, Орос хэлээр буй хэд хэдэн нэвтэрхий толийг харьцуулан үзэхэд “доминион” гэдэг нь зөвхөн Их Британийн хараат улсууд их төлөв 1907 оноос өмнө хэрэглэж байсан, арай хожим Энэтхэг, Голландын тухайд хааяа хэрэглэж байсан нэр томъёо ажээ. “Доминион”-ы үндсэн шинж нь: 1. Өөрийн засгийн газартай, 2. Английн хатан хааны төлөөлөгч амбан захирагч суудаг, 3. Өөрийн хил хязгаартай, 4. Өөрийн нийслэл хоттой байжээ. Манжийн эрхшээлд байсан Монголын хувьд үндэстэн хуваагдмал, Чин улсын хатуу хяналт бүхий тус тусын захиргаатай, өөрийн засгийн газар, нийслэл хотгүй байсан юм. Чингэхлээр гол зарим шинжээрээ Их Британийн хараат орон “доминион -той тэр бүр дүйцэхгүй байна. Гэхдээ Монгол улсын анхны Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн үзэл бодолд энэ талын судалгааг гүнзгийрүүлэхэд дөгөө өгөх нэгэн чухал санаа бий. Энэ нь хэдэн зууныг дамнан харийн эрхшээлд байсан үеийн Монголын түүхийг илүү нарийн, судалгааны онол-арга зүйн шинэ хандлагын үүднээс нягтлахыг сануулсан хэрэг юм.

Чингэхлээр Манжийн эрхшээлийн үеийн Монголын статус-квог тогтоохын тулд бүхэлд нь хараат түшмэг улс юм уу, колони байсан гэх зэргээр бүдүүвчилсэн биш нарийвчилсан шалгуур тогтоох үндсэн дээр үечлэн үзэж, түүхийн үнэнийг сэргээхийг эрмэлзэх хэрэгтэй байна. Бид өөрсдийнхөө өнгөцхөн судалгаанаасаа улбаалан дараах тойм төдий үечлэлийг дэвшүүлж, тухайн цагийн Монголын статус-квог тодорхойлох санал дэвшүүлж байна. Үүнд:

I. Монгол орон түшмэг хараат улсын байдалтай оршиж байсан үе. (XVII-XIX зууны эхэн) Энэ үед Манж нар Монгол орны стратегийн чухал газруудад үндэсний уламжлалыг нь харгалзан засаг захиргааны төв болон нэгж байгуулан, Энх-Амгалан хаан” шинэ дагасан халх нарыг түр тэдний ёсоор болтугай”⁶ хэмээн зарлиг буулгажээ. Энэ дагуу Монгол ноёд 1709-1795 оны хооронд 20 гаруй удаа чуулж, “Халх журам”-ыг хэлэлцэн тогтсон байна. Харин XVIII зууны сүүлчээр “Гадаад Монголын хууль зүйлийн бичиг” батлагдан гарч дагаж шийтгүүлэх болсноос хойш нийтээрээ дагах нь багасч, зөвхөн Их шавийн дотор хүчин төгөлдөр мөрдөгдөх болсон байна. Мөн энэ үеийн төгсгөлөөр алба татварын нэгдсэн тогтолцоо бүрэлдэн бий болсон, Монголын хил хязгаар хямгатай, нэлээд бие даасан байдалтай байсан зэргийг дурьдаж болно. XIX зууны дунд хүртэл Чин улсын бүрэлдхүүнд байсан угсаатан, нэн ялангуяа хятадуудыг нэг жилийн зөвшөөрөлтэй Монгол руу оруулж, суурьшин суух, монгол эхнэр авахыг хориглож байв. Энх-Амгалан хаан I Богд Өндөр гэгээн Занабазарыг зөвлөхөөрөө өргөмжилж, монгол бичгийг төрийн бичиг болгон авсан юм. Манж нар монголчуудад бусад үндэстнүүдээс арай илүү “дотно” хандаж байсны нэг илрэл бол монгол бичгийг авч, бинт, дусал төдийнхөн нэмэн хэрэглэсэн явдал юм. Монгол хэлнээс манж хэлэнд орсон үгсийн толь зохиосон АНУ-ын эрдэмтэн Уиллиам Розикки (William Rosicky) “Монголоос Манжид орсон болон хоёр хэлний дундын 1381 үг миний толинд бий. Толь гарснаас хойш нэмж бүртгэсэн, мөн

⁵ П.Очирбат. тэнгэрийн цаг. УБ, 1996

⁶ Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шаштир. 45-46 дугаар дэвтэр.

хүмүүсийн над хэлж өгсөн өөр олон үг бий”⁷ хэмээн ярьжээ. Тэр толийг эргүүлж үзвэл, манжаас монгол руу орсон үг нь их төлөв төр, захиргааны холбогдолтой нэр томъёо байна. Ийнхүү монголчуудад түшмэг хараат маягаар хандаж байсан нь нэг талаас, ургийн тусгаар эрх, “Алтан ураг” Чингис хааны нэр төртэй холбоотой, нөгөө талаас Манжийн эрх баригчид нүүдлийн болон суурьшмал орнуудыг эрхэндээ оруулсан их гүрэн байгуулсан боловч, хэр удаан тогтнох эсэхдээ эргэлзэн, амьдралын хэв маяг ойролцоо монголчуудыг цэрэг, улс төрийн түшмэг холбоотон байдлаар байлгаж, хэрвээ хятад дахь ноёрхлоо алдвал улсаа ядахдаа нүүдэлчдийн хэмжээнд барьж байх гэсэн эчнээ бодолтой холбоотой мэт.

Монголын ихэс дээдэс ч тухай үедээ өөрсдийгөө түшмэг хараат боллоо гэж үзэж байсан бололтой. Өнгөц төдий баримт сөхөхөд Манж нар: “Та цөм ах дүү харилцан хөнөөж булааж, сэв болж, дарагдаж олон аймаг сарнин хагацахад хүргүүлжээ. Тэр учраа 49 хошууны олон засгууд таны олныг хурааж авсан бөгөөс таны Халх нэр хэдийнэ сөнөх бүлгээ. Миний сэтгэл...таны эвдрэх сөнөхийг үзэж төвдөхгүй...таны сүслэж санах сэтгэл маш чин үнэнчийн тул туслан хишиг хүртээж, 49 хошууны ёсоор болгож миний дотоод, гадаадыг ялгалгүй нэгэн адил олдолгүй өршөөж үзсэн саналыг ухтугай” гэхийн хамт Монголыг “хараат бага улс”, “албан хүргэн ирэх улс” зэргээр нэрлэж, дотоод засгийн 49 хошуу ба гадаад засаг Халх зэргийн олон аймаг цөм хашаа түшээ” болно гэж үзэж байсан бол монголчууд тухайлбал Чахундорж”эртнээс нааш үе улиран эзэлсээр бүлгээ ... эзний хишиг хүртэж”, Занабазар “Богд эзний энх төрд түшиж аж төрвөл” гэсэн байхад угтаа монголчууд их Чин улсад гавъяа байгуулж, дагаж ороод улс төрийн хайгуул халхавч болсон гэж ойлгож байжээ. Гэхдээ Чин гүрэн Монголд засаг захиргаагаа тогтоосон хэргийг эцгийн эрхт ургийн хаант төрийн эзэнт улсын үзэл санаа, зарчмын илрэл гэж үзвэл зүйтэй мэт. Учир нь үндэстний эрин үеэс өмнө төв Азийн аль нэг нүүдэлчин угсаатнууд улс төрөө байгуулахдаа ямагт бусдыгаа өөрийн захиргаанд оруулж, хүчээ бэхжүүлэн, Хятад орныг “эзлэн” төвлөж, эзэнт улсаа байгуулдаг уламжлалтай билээ. Энэ бол төв Азийн нүүдэлчдийн эзэнт улсын үзэл санаа юм. Тиймээс эл үзэл санааг төлөөлөн эзэн болсон ургууд нь өөрийн ургийн хаанчлалыг чухамхүү эл түүхэн харъяаллаар тогтоосоор ирсэн нь тухайн үедээ “зүй ёсны” хэрэг байсан аж.

Тиймээс “Манж нар Монголыг эзэлж”, “Монголчууд даган орсон нь” хүчинд автсан хэрэг боловч чухамдаа өнөөгийн утгаар “эзлэн түрэмгийлсэн ба урван дагасан хэрэг бус” харин тэнгэрийн дор эзэнт гүрний сүр хүч, энх амгаланг тогтоох эзэнт улсын үзэл санаа, зарчмыг манжийн Чин ураг хэрэгжүүлсэн нэгэн ёсны “ээлж” таарсан гэсэн утгаар хэлж болох болов уу? Тиймээс энэ нь чухамхүү эзэнт гүрний эзэнт гүрний үзэл санаа ба “энхийг” тогтоохын тулд манж нар засаг захиргаагаа Монголд тогтоосон ба монголчууд ч үүнийг нь хүлээн зөвшөөрсөн ажээ.

Мөн тэр үед туурга тусгаар байдлын тухай өгүүлж болох авч бид үүнийг өнөөгийн үндэсний тусгаар тогтнолын утгаар ойлгож болохгүй, харин ургийн тусгаар эрхийн, тухайлбал “Алтан ургийн” ойлголтоор л авч үзэж болох юм. Тиймээс хэрвээ хэн нэгэн “урвагчийн” тухай ярихад хүрвэл түүнийг “Алтан ургийн” эзэн эрхийн үүднээс авч үзэхээс бус Монгол үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөний үүднээс авч үзэх нь зүйд нийцэхгүй юм.

Мөн үеийн эзэн хаадын хувьд тэнгэрийн дор хаан нэг байх явдал наад зах нь тунхаглал байсан учир энэ нь хаад харилцан зэрэгцэн оршихыг үгүйсгэхийн хамт энхийг тогтоох үндсэн арга зам нь гэрээ хэлэлцээр бус, харин хүчтэй нь

⁷ М.Саруул-Эрдэнэ. Индианагийн их сургуулийн монгол судлаачид. Блүүмингтон, Индиана. 2005.т.41

өөрийн засаг захиргааг тогтоосноор сая энхийг тогтоож байсан билээ. Эл энх тайвныг “*Rax Empirica*” буюу “эзэнт улсын энх тайван” гэж томъёолж болох бөгөөд энэ энх тайвныг энэ удаа Чин ураг тогтоосон учир үүнийг бид “*Rax Cinica*” буюу “Чингийн энх тайван” гэж ойлгож болох юм. Тиймээс Чингийн Монголд тогтоосон засаг захиргааны зорилго нь эл “энхийг тогтооход” чиглэгдэж байсан бөгөөд энэ нь тухайн үеийн нийгмийн түүхэн нөхцөл байдлаас уламжлан “Чин ураг” ба “Алтан ургийн” хооронд хаанчлалын холбоогоор дамжин тогтсон болно. Тиймээс Манж, Монголын хооронд тогтсон харилцаа бол үндсэндээ хамжлагын харилцаан дээр суурилсан эзэн, харъяатын харилцаа тогтсон хэрэг гэж үзэж болохоор байна. Чухам тийм учир 1691 онд Чин төрөөс Монголд хошуу, сум зохион байгуулж, хүн амыг сум, хамжлага, шавьд хуваан, “Алтан ургийн” тайж нарын язгуурын эрхийг “хүлээн зөвшөөрсөн” ба “Алтан ургийнханд” Чин ураг өөрсдийн цол, хэргэмийг “зүй ёсны дагуу” олгосон ажээ. Эл асуудалтай холбогдон тухайн үед манж нар Өвөр Монголыг захиргаандаа оруулсны дараагаар 1636 оноос “Чингисийн хас эрдэнэ тамгыг олж авсан” хэмээж оны цолоо “дээд эрдэмтийн тэргүүн он” гэж өргөмжлөхийн хамт мөн онд Халхын хангууд манжид анх “есөн цагаан” барьсан ба 1638 онд Манжийн эзэн хаан Халхын гурван ханыг жил бүр цагаан тэмээ нэжгээд, саарал морь наймаадыг бариулах зарлиг зарлиг буулгасан хийгээд, 1644 оноос эхлэн гадаад Монголын төрийг засах явдлын яамыг байгуулсан, 1655 онд Халхын 7 хошууг 8 болгож, дахин баруун, зүүн гар болгон хуваасан зэрэг үйл явдлыг ч эргэн харах хэрэгтэй юм.

Түүнчлэн “Чингийн энх тайван”-ы засаг захиргаа нь Монголд феодалын дажин самууныг зогсоож, “энх тайвныг” тогтоосон билээ. Мөн эл засаг захиргаа нь монголын нийгэмд дахин хамжлагачиллыг авчирсан юм. Хэдийгээр Чин ураг Монголын нэг хэсгийг хошуу, суманд хуваарилан “сум ард” болгон төрийн харъяат болгосон авч, “Алтан ургийн” тайж нарын язгуурын улс төрийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, засаг ноёд болгосон хийгээд, ард олныг хошуу, сумаас шилжин нүүдэллэхийг хориглосноор бодит байдал дээр сум ард ч гэсэн “Алтан ургийн” засаг ноёдын хамжлага болон үлдсэн юм. Чухам ургийн холбоо тогтсон учир монголын уламжлалт нийгмийн бүтэц хэвээр үлдсэн байна⁸.

II. Монгол орон хагас колонийн шинжтэй болсон үе. (XIX зууны дундаас XIX зууны сүүлч хүртэл) Энэ үед Монгол дахь Манжийн засаг захиргааны зохион байгуулалт бэхжин, хэлбэржиж, алба татварын тогтолцоо бүрэн төлөвшсөн байна. Манж чин гүрэнд Чингийн хаанчлал хэлбэрийн хувьд хүчирхэгжсэн мэт харагдавч, хэрэг дээрээ хятад түшмэдүүдийн арга башир, гарын аясаар хөдлөх болжээ⁹. Хятадуудыг Монголд нэг жилийн зөвшөөрөлтэй оруулж, гаргах хууль хүчинтэй байсан боловч, хятад хүмүүс Монгол нутагт олноор ирж суурьшин, худалдаа төдийгүй, тариа ногооны ажилаа эрхэлж байлаа. Тэд монгол эхнэр авах болсон. Тэдгээр хятадууд юухэн хээхнээр хуурч, монголын түүхий эдийг маш хямд үнээр авч, мөнгө хүүлж байв. Монголын ноёд дээдсийг өнгө мөнгөөр хуурч, өрөнд унаган эрхшээлдээ оруулж байжээ. XIX зууны сүүлчээр Орос болон бусад орны худалдааны капитал нэвтрэн орж ирж, Монголын хагас колони шинжийг улам гүнзгийрүүлэхэд хүргэсэн юм.

⁸ Манжийн эрхшээлийн үеийн Монгол. (Эрдэм шинжилгээний бага хурал. МУИС. 2001.V.15) УБ 2004.т.11

⁹ Jigjidin Boldbaatar and David Sneath. Ordering subjects: Mongolian Civil and Military Administration. (Seventeenth to Twentieth centuries). IMPERIAL STATECRAFT. Political forms and techniques of governance in inner Asia, sixth-twentieth centuries. Edited by David Sneath. Western Washington University. 2006

Чингэхлээр XIX зууны дундаас XIX зууны сүүлч хүртэл үеийг дан ганц Манжийн эрхшээлийн үе гэхээсээ Манж-Хятадын эрхшээлийн үе гэж нэрлэх нь илүү зохистой байна.

III. Монгол орныг бүрэн колоничлох замд шилжсэн нь. (XX зууны эхэн) Энэ үед Манж чин улс “Шинэ засгийн бодлого” гэгчээ Монголд нэвтрүүлж эхэлжээ. Энэ бодлого нь Монголд хятад иргэдийг үй олноор шилжүүлэн суурьшуулах, хүн амыг хятадчилах, том империалист гүрнүүдтэй нийлэн, түүхий эд, байгалийн баялгийг нь цөлмөх, Монголыг Манж-хятадын засаг захиргааны шууд нэг хэсэг болгох товчоор хэлбэл бүрэн колони болгон захирахад шилжсэн юм. Гэвч Чингийн ноёрхол нуран унаснаар эл бодлого хараахан бүрэн биелэлээ олоогүй билээ. Ийм маягаар, гэхдээ нарийвчлан шинжилж, шалгуур тогтоон судлавал Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүх илүү тод, бодитой болох болов уу.

4. Манжийн эрхшээлийн үеийн монголчууд харилцан адилгүй цаг үед манжийн хараанд орсоноосоо улбаалж, үндэстний нийтлэг буюу адилсал нь аажим, аажмаар бүдгэрч ирсэн юм. Жишээ: нь хамгийн түрүүнд Манжийн эршээлд орсон хорчингууд л гэхэд соёл, хэл, заншлын хувьд нэн өвөрмөц болсон байх жишээтэй. Оросын эрхшээлд орсон буриад монголчууд оросын соёлд уусч эхэлсэн. Хэдийгээр үндэсний хэл, соёлоо ямар нэг хэлбэрээр хадгалахыг эрмэлзэж, тэмцэж, тодорхой хэмжээгээр хадгалж байсан ч ондоосох үйл явц хүчтэй түрж, олон монголчууд ар, өвөр, буриад, халимаг мэтээр илт зааглагдаж, эрхшээж буй орныхоо хэл, соёлын нөлөөн дор өөр өөрийн өвөрмөц байдлаар ажиллаж, аж төрөн, амьдралын тодорхой хэв маягийг бүрдүүлж байв. Тэрхүү хэв маяг нь тухайн монголчуудын хэл, соёл, ёс заншилд алхам алхмаар шинэ өнгө аяс оруулах болжээ. Монголчууд эзэнт гүрнийхээ улс төрийн бодлогын нөлөөгөөр төдийгүй түүхэн цаг үеийн эрхээр ондоосож эхэлснийхээ харгайгаар бие биенээ “өөр нүдээр харах” буюу өө сэв эрэх, хажиглах шинжтэй болсон байна. Энэхүү түүхэн өвөрмөц үйл явцын нийтлэг ба онцлогийг нийтэд нь түүхэн нэгэн цаг үеийн ханан дээр суурьлуулан тавьж судлах эхлэл тавигдаж байна¹⁰. Үүнийг ингэж цогцолбороор авч үзэж, иж бүрдэл судалснаар өдгөө үед хэл, соёл, ёс заншлаа дахин сэргээхийг эрмэлзэж, хичээн зүтгэж буй монгол туургатнуудад алдаа, оноогоо дэнсэлж, түүхэн сургамж болгох чухал ач холбогдолтой юм.

5. Манжийн эрхшээлийн үеийн монголын нийгмийн давхраажлыг зөвхөн ангийн харъяалал, хуваагдлын үүднээс шинжилж байсан хязгаарлагдмал байдлыг өөрчилж, бодисын зүй, удамшил зүй, кастын тогтолцоо, аминчирхал-бүлгэрхэл, засаглалын бүтэц, нийгэм-мэргэжлийн учир шалтгаан, соёл-бэлгэ тэмдэг, соёлын хэм хэмжээ, нутаг дэвсгэрийн зэрэг хэв маягийн үүднээс шинжилж, нийгмийн хөдлөнг чанарын эх сурвалж, зүтгүүр, хөдөлгүүрийг нягт харгалзан үзэх шаардлагатай байна. Энэ чиглэлээр түүхэн социологийн үүднээс дүн шинжилгээ хийсэн ганц нэг бүтээл гарч буй¹¹. Хэдий тийм боловч Манжийн эрхшээлийн үеийн монголын нийгмийн давхраажлын асуудлыг дахин эргэцүүлэн үзэх асуудал тун түүхий хэвээр байна. Ганц жишээ дурьдахад, хэрэв түүхийн хувьд бурхны шашин уламжлалт монгол иргэншил, ахуй амьдралын салаа мөчир бүхнээ нэвчин шингэж, нүүдэллэн аж төрөх хэв маяг, зан заншил лугаа зохицсон өөрийн өвөрмөц өнгө аяс, дүр төрх бүхий монголын бурхны шашин нэгэнт бүрэлдэн тогтсон бол “монгол лам” хэмээх нийгмийн өвөрмөц бүлэг, давхраа гол нь Манжийн эрхшээлийн

¹⁰ Munkh-Erdene Lkhamsuren. Mongolian Identity and Nationalism: Origin, Transformation and Nature (From the thirteenth century to mid-1920-s) A Doctoral Dissertation submitted to the Graduate School of Letters, Hokkaido University. 2004. Bulag8 Uradyн E. Nationalism and identity in Mongolia. PhD dissertation. University of Cambridge. 1993. Nationalism and Hybridity in Mongolia. Oxford: Clarendon Press. 1998. Э.Хурц. Хорчин товчоо. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин 2001 он зэрэг

¹¹ Х.Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хандлага. (XX зуун) УБ.2002

жилүүдэд төлөвшин бүрэлдсэн нь эргэлзээгүй. Тухайлж хэлбэл, тэр нэгэн цагт төлөвшсөн “Монгол лам” буюу “Монгол хувраг” хэмээх нийгмийн давхраа сүсэгтэн олныхоо өмнө “Зовох нь бусдын хүчин бус өөрөө муу үйлдсэнийх, жаргах нь бас бусын хүчин бус өөрөө буян үйлдсэнийх” гэж номлон, буян, нүглийг дэнсэлж, нийгмийн гол, гол үүрэг, хариуцлагыг хүлээж, тухайн үеийн үлгэр жишээч амьдралын хэв маягийг үзүүлж байсан гэж хэлж болно. Монгол лам:

- Эх хүн хүндрэлгүй амаржихад туслана;
- Хүүхэд төрөхөд монгол, төвд, санскрит утга төгөлдөр нэр хайрлана;
- Үрийн хүслэн тэгшрээгүй гэр бүлд үрийн заяа хүсч залбирна;
- Хүүхэд өвдөхөд эмчилнэ, ад зэтгэр шүгэлсэн гэж үзвэл тарни, номын хүчээр зайлуулна;
- Хүүхдийн даахь үргээх ёслол найранд хүндтэй суудалд залран, сайныг ерөөнө;
- Банди нарыг өөртөө шавьлуулан, эрдэм номд амлуулахдаа ариун винайн ёс буюу дэг журамтай, шагшаабадтай, ёс тахимдуу байдалд сургана;
- Амьдралын аливаа асуудалд нягт нямбай, арвич хямгач хандах ухаан суулгаж, өдөр тутмын амьдралын зохистой хэрэглээг төлөвшүүлнэ;
- Эр,эм болж ёслох, хуримлахад мутрын болон номын адис хүртээж, амьдралын замыг ариутгана;
- Амьдралд тохиолдох аливаа зовлон, жаргалыг мэдэрч, эргэлзээтэй бүхнийг тайлах мэргэ төлгө буулгана.
- Хадан гэртээ ойртох цагт гэрээс захиасыг нь сонсож, өвдөж тарчилахыг нь нимгэлэхийг хичээнэ;
- Хан хорвоогоос халихад нь ерөөл уншиж, сайн төрөл олох, сүнсийг нь аврахад туслана;
- Номын хаялгаар хүнд итгэл сүсгийг үүсгэж, дотоод сэтгэлийн ариусал, гэгээрэл, амар амгаланг ханган, хүмүүн хоорондын харилцааг ээвэргүү зөөлөн, илүү ёс суртахуунлаг болгох үүрэг хүлээнэ. Бас лам хүн эхнэр авахыг хориглох, нийгмийн бурангуй явдал хүчтэй байсан нөхцөлд дэндүү хүлцэнгүй байдлыг номлох зэрэг сөрөг тал үүсгэж байсныг ч үгүйсгэх аргагүй юм. Энд би монгол ламын хамгийн ерөнхий төлөвийг дурьдсан бөгөөд тус бүрээр задлан шинжилж, илүү нарийн гаргалгаа хийж болохыг л сануулж байгаа хэрэг. Ийм арга зүйгээр Манжийн эрхшээлийн үеийн монголын нийгмийн бусад бүлэг, давхрааны нийгмийн дүр төрхийг зурж гаргах бололцоотой юм.

Эрхэм эрдэмтэн мэргэдийн сонорт Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийг хэрхэн үзэх талаар арга зүйн шинжтэй ийм хэдэн эргэцүүлэл бодомжийг хүргэх гэсэн юм. Миний өтлөнги санааг идэр залуугийн эрчтэй шинэлэг чанар мэргэн ухаанаараа ухварлан гүнзгийрүүлж, авах, гээхийн ёсны үүднээс хандан тольдох буй заа.

Abstract: The article offers the new approach to periodization of the Mongolian history during the Manchu administration and provides methodology for assessing the proper criteria for each of the proposed periods. In addition, the author proposes to revisit certain historical terms of the given period.